



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ
ХУЖИРТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 01 сарын 08 өдөр

Дугаар А/02

Хужирт сум

Цэргийн бүртгэл явуулах тухай

Батлан хамгаалах тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.4, Цэргийн албаны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.4 дэх заалт, аймгийн Засаг даргын 2021 оны "Цэргийн бүртгэл явуулах тухай" А/04 дүгээр захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Сумын 2021 оны цэргийн тоо бүртгэлийг 2021 оны 01 дүгээр сарын 15-ны өдрөөс 2021 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийг хүртэл явуулсугай.

2. Цэргийн шинэчилсэн тоо бүртгэл явуулах ажлын хэсгийг нэгдүгээр, тоо бүртгэл явуулах байр, хүлээлгэн өгөх хуваарийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

3. Багийн Засаг дарга нарт даалгах нь:

3.1. Цэргийн шинэчилсэн тоо бүртгэлийг заасан хугацаанд чанартай явуулах;

3.2. Хуваарийн дагуу тоо бүртгэлийн материалыг хүлээлгэн өгөх;


4. Цэргийн тоо бүртгэлийг заасан хугацаанд чанартай зохион байгуулан холбогдох байгууллагад 2021 оны 02 дугаар сарын 02-ны өдрийн дотор хүргүүлэхийг ажлын хэсгийн ахлагч (З.Цэцэгмаа)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Т.БАЯРМӨНХ

Сумын Засаг даргын 20²¹ оны 01 дүгээр
сарын 08 -ны өдрийн 02 дугаар
захирамжийн нэгдүгээр хавсралт



Тоо бүртгэл явуулах ажлын хэсэг

Ажлын хэсгийн ахлагч: З.Цэцэгмаа – Засаг даргын Тамгын газрын дарга

Гишүүд: Б.Пагамдулам – 1 дүгээр багийн Засаг дарга

Д.Батбаян – 2 дугаар багийн Засаг дарга

Д.Галиндэв – 3 дугаар багийн Засаг дарга

Д.Батбаяр – 4 дүгээр багийн Засаг дарга

Ц.Лхамролом – 5 дугаар багийн Засаг дарга


Ц.Амгалан – 6 дугаар багийн Засаг дарга

Г.Оюунмандах - Нягтлан бодогч

М.Чимэдрэгзэн - Нярав

-оОо-

Сумын Засаг даргын 2021 оны
01 дүгээр сарын 08 -ны өдрийн 40а дугаар
захирамжийн хоёрдугаар хавсралт



Тоо бүртгэл явуулах байр, хүлээлгэн өгөх хуваарь

Багийн нэр	Байр	Хүлээлгэн өгөх хугацаа
I	ЗДТГ-ын Иргэний танхим	2021.01.25
II	Багийн Засаг даргын өрөө	2021.01.25
III	Багийн Засаг даргын өрөө	2021.01.25
IV	ЗДТГ-ын Иргэний танхим	2021.01.26
V	ЗДТГ-ын Иргэний танхим	2021.01.26
VI	Багийн Засаг даргын өрөө	2021.01.26
Цэргийн штабт хүлээлгэн өгөх		2021.02.02

-oOo-